

- Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг учирч болзошгүй байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн аюул, төв, орон нутгийн газар зүйн байршил, эдийн засаг, нийгмийн онцлог, хөгжлийн бодлого, олон улсын жишиг үнэлгээний аргачлалд тулгуурлан боловсронгуй болгох;

- Болзошгүй гамшгийн эрсдэл, түүний нөлөөллийн талаарх статистикийн мэдээ, огөгдлүүдийг цуглуулах арга хэмжээг стандартчилах, гамшгийн мэдээллийн сангийн үйлчилгээг боловсронгуй болгох;

-Бүс нутгийн болон хил дамнасан болзошгүй гамшгийн эрсдэлийг үнэлэх;

-Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх;

-Эрсдэлийн зураглал, мэдээллийг боловсруулах, дамжуулах техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэсэн асуудлыг тусгасан байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад эрсдэлийг тодорхойлогч хүчин зүйлүүд болох аюул, эмзэг байдлыг бууруулах арга хэмжээнээс гадна түүнийг хэрэгжүүлэх байгууллагын чадавхийг сайжруулах үйл ажиллагаатай холбоотой. Онцгой байдлын албаны үйл ажиллагаа бүхэлдээ гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэдэг хэдий ч гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал нь олон талт нарийн төвөгтэй асуудал тул Онцгой байдлын алба төдийгүй холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлагдана. Гамшгийн эрсдэлийг бууруулж чадсанаар улс орны тогтвортой хөгжих нөхцөл боломж бүрдэж ялангуяа эдийн засгийн хөгжил болон хүний хөгжлийн асуудал нь уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчноос ихээхэн хамааралтай улсын хувьд байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал нэн тэргүүнд тавигдах шаардлагатай.

### **Дүгнэлт**

Манай оронд тохиолдож буй байгалийн аюулт үзэгдлийн давтамж дэлхий дахиныг хамарсан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр цаашид нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд улс орны эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл ч үүнийг дагаад өсөх магадлалтай юм.Иймд байгалийн аюулт үзэгдэлд тандан судалгаа, мониторинг хийж аюулыг эрт зарлан мэдээлэх, нийгэм, эдийн засгийг хөгжүүлж, аюулд өртөх эмзэг байдлыг багасгах зэрэг багц арга хэмжээгээр дамжуулж гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна.Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг бүх талын оролцоо, түншлэл хамтын ажиллагаанд тулгуурлан хийх нь ихээхэн үр дүнтэй болох нь дэлхийн улс орнуудын туршлагаар нэгэнт батлагдаад байгаа учир гамшгийн эрсдэлийг бууруулахын ач тусыг хүлээн зөвшөөрч бүх түвшинд энэ асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн  
821 дүгээр дамжааны сонсогч, ахмад  
Ц.Эрдэнэбилэг*

### **ГАМШИГ ОСЛЫН ҮЕИЙН УДИРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ**

Орчин үед дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын дулаарал болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг давамгайлах болж гамшгийн улмаас улс

орны тогтвортой хөгжил, хүн ам хүрээлэн буй орчинд учирах хохирол нэмэгдэж, хөгжлийн явцыг сааруулж, үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх гамшигт үзэгдлийн тоо давтамж өссөөр байна. Монгол оронд ч ган зуд, ой хээрийн түймэр, цасан болон шороон шуурга, үер ус, газар хөдлөлт гэх мэт байгалийн гамшгууд жилийн дөрвөн улиралд ээлжлэн тохиолдож байдаг. Тэр дундаа хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй ой хээрийн түймрийн давтамж жил бүр ихсэж байна.

Иймд дээрхи гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах болон аврах, хор уршгийг арилгах, гамшгийг хохиролгүй даван туулах,сэргээн босгох, хохирлын хэмжээг дээд зэргээр бууруулахад чиглэгдсэн цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх явдал нь гамшгийн удирдлагын үл тасалдах үргэлжилсэн арга хэмжээ юм. Гамшиг ослын үед эрэн хайх, аврах ажиллагааг амжилттай гүйцэтгэх нэг чухал үндэс нь удирдлага, зохион байгуулалт мөн.

Гамшгаас хамгаалах удирдлага гэдэг нь гамшгийн янз бүрийн үе шатанд болон бүх түвшин дэхь үндэсний бодлого, засаг захиргааны шийдвэр, шуурхай үйл ажиллагааны нэгдэл юм. Гамшгаас хамгаалах ерөнхий удирдлага нь аюул, осол, сүйрлээс урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгохтой холбогдсон асуудлыг улс орны хэмжээнд гүйцэтгэнэ<sup>1</sup>. Гамшиг ослын үеийн удирдлага зохицуулалт нь гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээллийг хором бүрт авч, авсан мэдээлэл бүрт дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргаж аврагч нарыг тогтвортой, тасралтгүй удирдлагаар хангаж ажилладаг.

Гамшиг ослын үед аврах ажлын удирдлага нь төлөвлөгөө боловсруулах,, үүрэг даалгавараар хангах, түүний биелэх нөхцлийг хангаж өгөх, хяналт тавих, боловсруулсан төлөвлөгөөнд засвар, өөрчлөлт оруулах, идэвхжүүлэх, тайлагнах үйл явцыг хангаж ажиллана. Мөн ажиллагаанд оролцож буй техник, хүн хүчний харилцан ажиллагааг зохион байгуулах, ажлын аюулгүй нөхцөл байдлыг бүрдүүлж ажиллана. Гамшгийн үеийн удирдлага нь нэгдмэл, нэгэн хариуцлагын тогтолцоотой байна. Гамшгийн удирдлагын зорилго нь:

- хүн амын эмзэг байдлаас үүсч болох гамшгийн болзошгүй хохирлыг бууруулах, хэрэв боломжтой бол бүрмөсөн арилгах;
- гамшигт нэрвэгдсэн хүн амд яаралтай тусламж үзүүлэх;
- урьд байсан эрсдэлээс бага эрсдэлтэй болгохын тулд үр дүнтэй, урт хугацааны сэргээн босгох арга хэмжээг авахад оршино.

Гамшгийн аюулыг бууруулах арга хэмжээ гэдэг нь гамшгийн эмзэг байдлыг бууруулснаар ирээдүйд гарч болзошгүй гамшгийн хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах зорилгоор инженерийн болон инженерийн бус арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хэлнэ. Инженерийн арга хэмжээнд үерийн уснаас хамгаалах далан суваг байгуулах, газар хөдлөлтөнд тэсвэртэй барилга байгууламж барих, өвс тэжээл бэлтгэх, уст цэг гаргах, малын хашаа хороо босгох, түймрээс хамгаалах зурвас татах зэрэг бүтээн байгуулалтын ажлууд орно.

Инженерийн бус арга хэмжээ нь холбогдох хууль тогтоомж гаргах, газар ашиглалтыг зохистой төлөвлөх, газар хөдлөлтийн эсрэг барилгын код стандартыг

<sup>1</sup> О.Үржин. Эрэн хайх,аврах ажлын үндэс. УБ. 2012.

мөрдүүлэх, хот төлөвлөлтийг сайжруулах, хүний амь, эд хөрөнгийн даатгалыг өргөжүүлэх болон бусад үйл ажиллагаанаас бүрдэнэ. Гамшгийн бэлэн байдлыг хангах үе шат нь “Хамгаалалтын хоёр дахь зурвас” юм. Энэ үе шатны арга хэмжээний үндсэн зорилго нь гамшиг гарсан үед түүний хор уршгийг хэрхэн шуурхай бөгөөд үр дүнтэй арилгах, гамшгийн үед гарч болзошгүй бэрхшээлийг урьдчилан төсөөлсний үндсэн дээр тэдгээрийг хэрхэн оновчтой шийдвэрлэх талаар төлөвлөж, зохих бэлтгэлийг хангахад оршино.

Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээнд:

- Эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийх
- Бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах
- Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах
- Дадлага сургууль хийх
- Гамшгаас сэрэмжлүүлэх ажлыг хийх
- Эрт зарлан мэдээллийг шуурхай дамжуулах
- Зохих нөөцийг бүрдүүлэх
- Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зэрэг ажлууд орно.

АНУ-ын гамшгийн нэрт судлаач Фрэдэрик Кьюнигийн хэлснээр 'Гамшгийн удирдлагын салбарт хамгийн их боломж, бололцоо олгодог үе шат нь бэлэн байдлыг хангах үе<sup>1</sup>' гэжээ. Энэ нь бэлэн байдлыг цаг тухайд нь хангах явдал ямар ач холбогдолтой болохыг харуулж байгаа юм.

Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ гэдэг нь гамшиг болохоос өмнөхөн, гамшгийн үед болон түүний хөнөөлийн дараа эрэн хайх, аврах ажиллагаа, яаралтай эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хийгээд бусад хойшлуулшгүй ажлуудыг авч хэрэгжүүлэхийг хэлнэ. Хор уршгийг арилгах үе шатанд эрэн хайх, авран хамгаалах арга хэмжээ их ач холбогдолтой бөгөөд гамшигт нэрвэгдэгсдийг аврах, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түр орогнох байр, хүнсээр хангах, холбоо мэдээллийг зохион байгуулах, ус хангалт хийх, эрүүл мэнд, ариун цэврийн үйлчилгээ үзүүлэх, зам харгуйг чөлөөлөх, чухал объектыг сэргээх болон бусад үйл ажиллагаа орно.

Гамшгийн судалгаанаас дүгнэлт хийхэд гамшгийн хор уршгийг арилгахад ерөнхийдөө-дараах хүндрэл бэрхшээлүүд гардаг байна.

- Хүч хэрэгслийг дайчлах, татан оролцуулахад цаг алдах
- Хохирлын үнэлгээ, хэрэгцээг тодорхойлох чадавхи муу
- Гамшгийн мэдээ, мэдээллийн чанар хангалтгүй
- Ар талын хангалтын хүндрэл бэрхшээл
- Хэвлэл мэдээллийн байгууллагаас учрах бэрхшээл
- Нэрвэгдэгсдийн хэрэгцээг үл хангах тусламж ирэх
- Гамшгийн үеийн зохицуулалт муу байх явдал гардаг
- Өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг сул
- Гамшиг ослын аюулын мэдлэг тааруу гэх мэт зүйлүүд тулгардаг байна.

<sup>1</sup>Ш.Болдбаатар. Гамшгийн менежмент. УБ. 2003.

Гамшгийн өмнөх үеийн удирдлагын алдаатай бодлогын уршгаар улсын хэмжээнд гамшигтай тэмцэх, түүнийг даван туулах бэлтгэл, бэлэн байдлыг хангахад алдаа дутагдал үүсэн гардаг байна.

Сүүлийн 10 жилд ТОХИОЛДСОН гамшиг ослын судалгаанаас авч үзэхэд ой хээрийн түймэр 1807, объектын гал 23238, хүний гоц болон хурц халдварт өвчин 118, малын гоц халдварт өвчин 138, шувууны томуу өвчин 3, усанд осолдсон золгүй тохиолдол 497, хүчтэй цасан болон шороон шуурга 121, үерийн аюул 147, аянга 50, зуд 9, газар хөдлөлт 58, үйлдвэр, зам тээвэр, галт тэрэг, онгоцны осол 50 удаа тус тус тохиолдсоны улмаас 1330 хүний амь нас эрсдэж, 900 орчим хүн өвчилж, 9,2 сая мал хорогдож, 9,7 сая га ой хээрийн бүс, 3891 гэр, байшин, 227 хашаа, саравч түймэрт шатаж 632,3 тэрбум төгрөгний хохирол учирсан байна. Байгалийн гамшгийн улмаас улс орны нийгэм, эдийн засагт жил бүр ойролцоогоор 70,2 орчим тэрбум төгрөгний хохирол учирч байгаа нь 10 жилийн өмнөхтэй харьцуулахад бараг 10-14 дахин, гамшгийн улмаас амь насаа алдсан хүний тоо жил бүр дунджаар 121 болж байгаа нь 2 дахин өссөнийг харуулж байна<sup>1</sup>.

Эдгээр гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ нь богино хугацааны үйл ажиллагаа ч гэсэн энэ нь ирээдүйд эмзэг байдлыг бууруулах суурь нөхцлийг бүрдүүлдэг юм. Сэргээн босгох ба сэргээн засварлах арга хэмжээ нь хүн амын аж амьдралыг хэвийн байдалд оруулахдаа холбогдсон ажлуудыг хэрэгжүүлдэг. Гэхдээ хэвийн хэмжээний гэсэн гамшгийн өмнөх нөхцөл нь гамшгийн эмзэг байдлыг агуулж түүнээс болж гамшгийн нөхцөл байдал бий болсон бол хор уршгийг арилгах арга хэмжээ нь энэхүү нөхцөлийг улам сайжруулах чанарын өндөр түвшинд гаргах эрсдлийн хэмжээг бууруулах зорилготой байна.

Сэргээн босгох болон сэргээн засварлах арга хэмжээ нь ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдэж тухайн улс орны үндэсний хөгжлийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг байх ёстой. Гамшгийн удирдлагын үе шатуудыг бид ерөнхийд нь хэлэлцлээ. Хэдийгээр гамшгийн удирдлагын үйл ажиллагааг онолын хувьд бид гамшгийн аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, сэргээн засварлах үе шатанд хувааж ангилсан хэдий ч эдгээр үе шатанд хэрэгжих арга хэмжээ нь зөвхөн ангилсан хүрээнд хэрэгждэг гэж ойлгож болохгүй. Жишээ нь: хүн амыг аюултай газраас нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг гамшиг гарахаас өмнө зохион байгуулж болдог. Иймд энэ үе шатыг цаг хугацааны хувьд ангилах боломжгүй нь ойлгомжтой.

Гамшгийн үеийн удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлдөг зарим хүчин зүйлсийг авч үзье.

- Гамшигт өөрөө өртөж бэртсэний улмаас томилогдсон зарим удирдлага жагсаалаас гарах
- Онцгой хүнд нөхцөлд ажиллах дадлага туршлагагүйгээс томилогдсон дарга үүрэг гүйцэтгэх удирдах чадваргүй болох
- Янз бүрийн хямралт нөхцөл байдлаас болж бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадвар үр бүтээл буурах

<sup>1</sup>Судалгааны тайлан. Гамшиг судлалын хүрээлэн. УБ. 2012.

- Шийдвэр гаргахад шаардлагатай мэдээ мэдээллээр удирдлага дутагдах, эсвэл удирдлагад буруу мэдээлэл танилцуулах

- Удирдлагаас доод тушаалын чухал мэргэжлийн хүмүүст заавар зөвлөлгөө өгөх, тэдэнд яаралтай тусламж явуулах нөхцлийг хангах, холбооны хэрэгсэл эвдэрч гэмтэх, ажилгүй болох

- Гамшгийн дараах хүнд хэцүү байдал нь удирдлагаас өөрийнхөө үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход бэрхшээл учруулах

- Аврах ажил явуулах шаардлагатай мэргэжилтэн багаж хэрэгсэл, машин техник зэрэг нөөц хүч хэрэгсэл, хохирох гэх мэт олон зүйлийг дурдаж болох байна.

Тухайн онцлог нөхцөл байдлаас хамаарч гамшгийн үед удирдлагад нөлөөлж болох олон хүчин зүйл байх нь мэдээж юм. Гамшгийн хөнөөл уршгийг арилгах арга хэмжээ нь гамшигт нэрвэгдэгсдэд болон түүнтэй тэмцэх ажлыг удирдах мэргэжилтний аль алинд нь маш их шаардлага тавихуйц нөхцөл байдал үүсдэг. Ийм учраас энэхүү арга хэмжээг зохион байгуулж явуулахын тулд асуудлыг шуурхай, ухаалаг, оновчтой шийдвэр гаргах чадвар эзэмших зайлшгүй шаардлагатай.

Гамшгийн аюулыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэхэд гамшгийн менежментийн үндэсний бодлого, гамшигтай тэмцэх хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлын зэрэг, гамшгийн үеийн бүхий л арга хэмжээ, гамшгаас хамгаалах талаар төлөвлөлт, зохион байгуулалт, материал хэрэгслийн нөөц, төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүйн орчин, болон бусад асуудлууд багтдаг.

Гамшгаас хамгаалах талаар баримтлах төрийн бодлого нь төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, эдгээр үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. УИХ-аар батдагдсан Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд:

1. Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог хангаж төв, орон нутгийн төрийн ба мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах.

2. Гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах.

3. Гамшгийн нэр томъёоны ойлголт, төрийн болон хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах чиг үүрэг, тогтолцоо, гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, гамшгийн үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

4. Аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологийг нэвтрүүлж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсруулж, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулах.

5. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхийг бэхжүүлэх зэрэг асуудлууд тусгагдсан бөгөөд дээрх арга хэмжээг шат шатанд хэрэгжүүлэх, биелэлтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

### **Дүгнэлт**

Бидний судалгаагаар бүх гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаа бүр давтагдан гарч байсан бэрхшээлтэй асуудал бол гамшгийн зохицуулалт байлаа. Учир нь гамшгийн хор уршгийг арилгах үе шатанд олон төрийн болон төрийн бус

байгууллага гамшгаас хамгаалах албад мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн аж ахуй нэгж байгууллага, олон улсын байгууллага, дотоод гадаадын иргэд оролцдог тул эдгээр байгууллага, албан тушаалтан иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж нэгэн чигт хандуулах нь ямар их ач холбогдолтойг харуулж байгаа юм.

Үүний тулд тохиолдож буй гамшгаас учирч болох хор уршгийг нэгтгэн дүгнэх, аюулыг бууруулах арга хэмжээг тодорхойлох, сэргийлэх, хамгаалах, аврах, тусламж үзүүлэх байгууллага, хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, гамшиг осолтой тэмцэх ажлыг зохион байгуулах, сургалт, хүн амд ухуулга, сурталчилгаа хийх, гамшигтай тэмцэх талаар цаашид “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого” хөтөлбөрийг оновчтой хэрэгжүүлж ажиллах нь чухал байна.

Хөдөө орон нутгийн иргэд бэлчээрийн мал аж ахуйг түшиглэн ажиллаж амьдарч байгаа нь өвөл, хаврын улиралд байгалийн аюулт үзэгдэлд өртөх, ихээхэн хэмжээний хохирол учирах эрсдэлтэй байдаг. Иймээс улирлын шинж чанартай гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд гамшгийн удирдлагыг боловсронгуй болгох хэрэгцээ байгаа нь үүссэн нөхцөл байдлаас харагдаж байгаа юм.

Аливаа улс орон иргэдээ гамшиг, осол, сүйрлээс хамгаалах үүрэгтэй, үүргээ биелүүлэх институцтай байдаг.

Гамшиг, осол, сүйрэл, хөнөөлийн голомтод юуны өмнө Онцгой байдлын алба, цэрэг, цагдаа, хүчний болон төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд хүний амь нас, эд хөрөнгө, үнэт зүйлсийг аврахаар ажилладаг билээ.

Иймд гамшгийн үеийн удирдлага зохицуулалтын асуудлыг нарийвчлан судалж, хамтын ажиллагааны оновчтой загвар бий болгох асуудал тулгамдаж байна.